



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/402

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.29 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, ажиллуулах журам”-ыг нэгдүгээр, “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн мэргэжлийн үйл ажиллагааны төслийг хянах үнэлгээний хуудас”-ыг хоёрдугаар, “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байрны үнэлгээний дүгнэлтийн хуудас”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шинжээчидтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, үнэлгээ хийх болон ёс зүйн сургалтад хамруулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Тусгай зөвшөөрлийн комиссын дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төгсдэлгэрт даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Журам шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11
сарын 20 өдрийн 1/102 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ОРОН ТООНЫ БУС ШИНЖЭЭЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ, АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчийн төслийн баримт бичиг болон ажлын байранд үнэлгээ хийж, дүгнэлт гаргах орон тооны бус шинжээч (цаашид “Шинжээч” гэх)-ийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, ажиллуулах, чөлөөлөхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан эрүүл мэндийн болон аж ахуйн нэгж байгууллагын төслийн баримт бичиг, ажлын байранд хөндлөнгийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргахаар томилогдож, шинжээчийн болон ёс зүйн сургалтад хамрагдсан мэргэжилтнийг “орон тооны бус шинжээч” гэнэ.

1.3. Орон тооны бус шинжээч ажиллуулахтай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын холбогдох нэгж (цаашид ажлын алба) удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

Хоёр. Шинжээчийн сонгон шалгаруулалт

2.1. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь орон тооны бус шинжээчийн сонгон шалгаруулалтыг 3 жил тутамд нээлттэй хэлбэрээр зохион байгуулна.

2.2. Шинжээчийн сонгон шалгаруулалтын зарыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн болон бусад хэрэгслээр 21 хоногийн хугацаанд нийтэд зарлан мэдээлнэ.

2.3. Шинжээчийн сонгон шалгаруулалт зарласан тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1. Шинжээчид нэр дэвшиж буй мэргэжилтний баримт бичгийг хүлээн авах, хянан нэгтгэх;

2.3.2. Сонгон шалгаруулалтын дүнг дууссанаас хойш ажлын 10 өдөрт багтаан Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар хэлэлцүүлэх;

2.3.3. Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтэд нийцсэн “Шинжээч”-ээр томилох мэргэжилтнүүдийн нэрсийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулах;

2.3.4. Сонгон шалгаруулалтад тэнцээгүй мэргэжилтэнд ажлын 5 хоногт багтаан эргэн мэдэгдэх;

2.3.5. Сонгон шалгаруулалтын дүнг мэдэгдсэнээс хойш шинжээч сонгон шалгаруулах үнэлгээний ажлын хэсэгт гомдол гаргах хугацаа ажлын 5 хоног байх бөгөөд ажлын 10 хоногт багтаан хариу тайлбарыг хүргүүлэх;

2.3.6. Гомдол гаргах хугацаа өнгөрсөн эсхүл гомдлыг шийдвэрлэж, мэдэгдсэнээс хойш сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнтэй “хөлсөөр ажиллах гэрээ” байгуулах тухай мэдэгдэл хүргүүлж, зөвшилцсөний үндсэн дээр гэрээ байгуулах.

**Гурав. Шинжээчид тавигдах шаардлага,
сонгон шалгаруулалт**

3.1. Тусгай зөвшөөрлийн шинжээч нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

3.1.1. Монгол Улсын иргэн;

3.1.2. Насны дээд хязгаар 65 нас;

3.1.3. Анагаах ухаан болон бусад шаардлагатай мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн;

3.1.4. Мэргэшлийн зэрэг эсхүл эрдмийн зэрэг цолтой;

3.1.5. Тухайн мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан байх;

3.1.6. Компьютерийн хэрэглээний програм болон тусгай зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн цахим програмыг бүрэн эзэмшсэн байх;

3.1.7. Эрүүл мэндийн удирдлага, тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, тухайн мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтад хамрагдсан байх;

3.1.8. Эрүүл мэндийн байгууллагын болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, протез, лабораторийн урвалж, оношлууур үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, худалдах, үйлчилгээ эрхлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх ажлын дадлага, туршлагатай байх;

3.1.9. Шинжээч өөрийн нэр дээр болон хамтарсан байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байх;

3.1.10. Хууль, эрх зүйн мэдлэгтэй, бичиг баримт боловсруулах, хариуцлага хүлээх чадвартай байх;

3.1.11. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;

3.1.12. Ес зүйн зөрчил гаргаагүй байх;

3.1.13. Авлига ашиг сонирхлын зөрчилгүй байх.

3.2. Шинжээчээр ажиллахыг хүссэн мэргэжилтэн нь дараах баримт, бичгийг бүрдүүлнэ.

3.2.1. Хувийн өргөдөл;

3.2.2. Төрийн албан хаагчийн анкет;

3.2.3. E-Mongolia цахим хуудаснаас авсан иргэний үнэмлэхний хуулбар;

3.2.4. Дээд боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх, эрдмийн болон мэргэшлийн зэрэг, цолыг нотлох баримтын хуулбар;

3.2.5. Мэргэшлийн чиглэлээр урт, богино хугацааны сургалтад хамрагдсаныг нотлох баримтын хуулбар;

3.2.6. Ажил эрхэлдэг бол тухайн байгууллагын тодорхойлолт;

3.2.7. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл (Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягт);

3.2.8. Ёс зүйн салбар хорооны тодорхойлолт;

3.2.9. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт;

3.2.10. 3x4 хэмжээтэй 1 хувь цээж зураг.

3.3. Ажлын алба нь нэр дэвшигчийн баримт бичгийн бүрдлийг хянаж, хүлээн авч бүртгэнэ.

3.4. Шинжээчээр нэр дэвшигч нь уг журмын 3.1; 3.2-т заасан шаардлагыг хангаж, баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн тохиолдолд ажлын албанаас ур чадварын үнэлгээг зохион байгуулна.

3.5. Үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Тусгай зөвшөөрлийн комиссын хуралд тухай бүр санал оруулж шийдвэрлүүлнэ.

3.6. Үнэлгээг асуудал шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх, удирдан зохион байгуулах, багаар ажиллах, тайлагнах, илтгэх, компьютерийн хэрэглээний програм болон цахим орчинд ажиллах зэрэг ур чадварыг үнэлнэ.

3.7. Үнэлгээний дүн нь ажлын хэсгийн гишүүдийн гарын үсэг бүхий тэмдэглэл, дүнгийн хуудсаар баталгаажна.

3.8. Үнэлгээний дүнг Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.9. Тусгай зөвшөөрлийн комиссын хурлын шийдвэрийг үндэслэн сонгогдсон шинжээчийг Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын албан тушаалтнаар баталгаажуулна.

Дөрөв. Шинжээчийн эрх, үүрэг

4.1. Шинжээч нь үнэлгээ хийх удирдамжийн дагуу томилогдсон аж ахуйн нэгж, байгууллагын холбоо барих утасны дугаар, хаяг байршлын мэдээллийг ажлын албанаас авах эрхтэй.

4.2. Шинжээч нь үнэлгээ хийхээр томилогдсон байгууллагын чиглэл, төрөл, газар зүйн байршил зэргийг харгалзан саналаа хэлэх эрхтэй.

4.3. Шинжээчийн ажлын байрны үнэлгээ хийхээр томилогдсон аж ахуйн нэгж, байгууллага нь хамаарал бүхий этгээд (эцэг эх, эхнэр нөхөр, ах эгч, дүү, хүүхэд, найз нөхөд, танил) байх тохиолдолд шинжээчээр ажиллахаас сайн дураар татгалзаж, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг бөглөж, татгалзах эрхтэй.

4.4. Тусгай зөвшөөрлийн комиссын даргын баталсан удирдамж, шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрөл хүсэгчийн бүрдүүлсэн баримт бичигтэй урьдчилан танилцаж, ажлын байранд ажиллах үүрэгтэй.

4.5. Шинжээч нь мэргэжлийн үйл ажиллагааны төслийн үнэлгээ хийж, дүгнэлтийг 2 хувь үйлдэж, 1 хувийг ажлын албанд хүлээлгэн өгч, 1 хувийг өөртөө хадгална.

4.6. Шинжээч нь нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн баримт бичгийн хүрээнд ажиллах үүрэг хүлээнэ.

4.7. Шинжээчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гарах аливаа хариуцлагыг шинжээч өөрөө хариуцах үүрэгтэй.

4.8. Шинжээч нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой ажил, үүргийн хүрээнд олж авсан мэдээллийн нууцлалыг хууль тогтоомжид заасан хүрээнд задруулахгүй байх үүрэгтэй.

4.9. Холбогдох хууль эрх зүйн баримт бичиг, олон улсын туршлага, мэдээлэлтэй танилцаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх үүрэгтэй.

4.10. Шинжээч нь ажлын байранд батлагдсан удирдамжийн дагуу холбогдох журам, зааврын дагуу үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, нэмэлт шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, баримтжуулах, дүгнэлт гаргах, танилцуулга бэлтгэх үүрэгтэй.

4.11. Шинжээч нь ажлын байрны хяналт, үнэлгээ хийхтэй холбоотой хөндлөнгийн нөлөөнд автахгүй, дүгнэлтийг үнэн зөв гаргах үүрэгтэй.

4.12. Шинжээч нь өөрийн үнэлгээний дүгнэлт, хавсралт баримт бичгийн үнэн зөв байдлыг хариуцах, алдаатай тохиолдолд ажил гүйцэтгэх эцсийн хугацаанаас өмнө залруулах үүрэгтэй.

4.13. Шинжээч нь мэргэжлийн үйл ажиллагааны төслийн үнэлгээ болон шинээр тусгай зөвшөөрөл хүсэгчийн ажлын байрны үнэлгээний дүгнэлтийг Тусгай зөвшөөрлийн комиссын хуралд танилцуулж, шийдвэр гаргуулах үүрэгтэй.

4.14. Шинжээч нь ажлын байрны хяналт, үнэлгээ хийхтэй холбоотой хөндлөнгийн нөлөөнд автахгүй, дүгнэлтийг үнэн зөв гаргах, Авлигын эсрэг хуулийн 7.1 дэх хэсгийн 7.1.1-7.1.3, 7.1.5, 7.1.6-д заасан хөндлөнгөөс нөлөөлсөн аливаа дарамт шахалт, зохимжгүй нөлөөлөлд автахгүй байх бөгөөд эдгээр оролдлого гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу мэдэгдэх үүрэгтэй.

4.15. Шинжээчдийг эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд явцын хяналтын үйл ажиллагаанд оролцуулж болно.

Тав. Шинжээч томилон ажиллуулах

5.1. Тусгай зөвшөөрөл шинээр хүсэгчийн мэргэжлийн төсөл дэмжигдсэн, тусгай зөвшөөрөл дэх хаяг байршил өөрчлөгдөх, сунгалт хийх үед Тусгай зөвшөөрлийн комиссын даргын удирдамж, шийдвэрээр ажлын байранд шинжээчдийн баг эсхүл ажлын албаны мэргэжилтэнг оролцуулсан хамтарсан баг томилон ажиллуулна. Үүнд:

5.1.1. Холбогдох мэргэжлийн мэргэшсэн шинжээчдийг сонгох;

5.1.2. Баг нь 2-3 хүний бүрэлдэхүүнтэй байх (тусгай зөвшөөрөл шинээр хүсэгчийн ажлын байранд 3, бусад тохиолдолд 2 хүн);

5.1.3. Шинжээчийн баг нэг ажлын байранд 1 удаа очиж ажиллах ба тусгай зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтээр дахин 1 удаа очиж ажиллаж болно;

5.1.4. Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх үүднээс шинжээчийн хувийн хэргийн мэдээллийг судалж, тодруулсны дараа ажлын байрны үнэлгээг хийх багийг томилох.

5.2. Шинжээчийн баг үнэлгээ хийхдээ дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

5.2.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллагын удирдлага, ажилтнуудад ажлын удирдамжийг танилцуулна.

5.2.2. Ажлын байрны дүгнэлт, зөвлөмжийг тухайн байгууллагын удирдлагад танилцуулж, стандарт хангасан эсэхийг зураг, дүрсээр баримтжуулна.

5.2.3. Үнэлгээний тайлан, зөвлөмжийг шинжээч нар гарын үсгээр баталгаажуулж, үнэлгээ дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан ажлын албанд хүлээлгэн өгнө.

5.2.5. Шинжээчид үнэлгээ хийсэн байгууллагын талаарх мэдээллийг бусдад задруулахгүй, нууцыг хадгална.

Зургаа. Ажлын албаны чиг үүрэг

6.1. Ажлын алба нь шинжээчийг ажиллуулахдаа дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

6.1.1. Ажлын байрны үнэлгээний дараа аж ахуйн нэгж, байгууллагаас шинжээч нарын үйл ажиллагаатай холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авах, нээлттэй утас болон цахим хаяг ажиллуулж, мэдээлэл авч, дүн шинжилгээ хийх;

6.1.2. Шинжээчийн мэдээллийн нууцлалыг хадгалах;

6.1.3. Шинжээчтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

6.1.4. Шинжээч нарт сургалт зохион байгуулах;

6.1.5. Батлагдсан удирдамжийн дагуу шинжээч ажиллах боломжгүйгээ илэрхийлсэн болон үнэлгээний дүгнэлтийг хугацаанд нь гаргаж ирүүлэх боломжгүй болсон тохиолдолд ажлын алба дахин шийдвэр гаргаж, шинжээч томилон ажиллуулах;

6.1.6. Шинжээчийн хувийн хэрэг хөтөлж, хувийн хэрэгт төрийн албан хаагчийн анкет, шинжээчийн мэргэжил, боловсролын үнэмлэх болон иргэний үнэмлэхийн хуулбар, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх урьдчилсан мэдүүлэг, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дүн, бусад шаардлагатай мэдээллийг бүрдүүлж мэдээллийн сан үүсгэх, тогтмол баяжилт хийх;

6.1.7. Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагад зөвшөөрөл авсанаас хойш тодорхой хугацааны дараа явцын хяналт хийх бөгөөд шинжээч нарыг сэлгэн байршуулж, удирдамж гарган ажиллуулах;

6.1.8. Шинжээчийн ажилласан ажлын гүйцэтгэлд үндэслэн ажлын хөлс олгох;

6.1.9. Шинжээчийн үнэлгээ хийсэн дүгнэлт, ажлын тайлан, баримт бичгийг хүлээн авч цахим болон цаасан хэлбэрээр хадгалах, архивлах.

Долоо. Шинжээчийн гэрээг дүгнэх, чөлөөлөх

7.1. Шинжээчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг жилийн эцэст ажлын алба, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллага, шинжээчдийн оролцоог хангаж зохион байгуулна.

7.2. Гэрээний биелэлтийг хагас жил тутамд дүгнэж, гэрээний хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

7.3. Шинжээчийг дараах тохиолдолд чөлөөлж, шинжээчтэй хийсэн гэрээг цуцална.

7.3.1. Өөрийн хүсэлтийг үндэслэн;

7.3.2. Мэргэжлийн алдаа болон ёс зүйн зөрчил гаргасан нь холбогдох байгууллагаар тогтоогдсон;

7.3.3. Авлига, ашиг сонирхлын зөрчил гарсан нь нотлогдсон;

7.3.4. Байгууллага, хувь хүний нууцыг задруулсан нь тогтоогдсон;

7.3.5. Хуурамч дүгнэлт гаргасан;

- 7.3.6. Хараат бус байдлыг хангаж ажиллаагүй, хөндлөнгийн нөлөөлөлд автсан нь тогтоогдсон;
- 7.3.7. Гэрээний үнэлгээгээр 2 ба түүнээс дээш удаа хангалтгүй дүгнэгдсэн;
- 7.3.8. Комиссын хуралд тодорхойгүй шалтгаанаар 2 удаа танилцуулга хийгээгүй;
- 7.3.9. Гэрээний заалт зөрчсөн;
- 7.3.10. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон, эсхүл авилгын болон албан тушаалын хэрэгт буруутгагдаж хууль зүйн хариуцлага хүлээсэн бол.

Найм. Бусад зүйл

8.1. Давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас шинжээч ажиллах боломжгүйгээс шалтгаалан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд гарах аливаа хариуцлагыг комисс хариуцахгүй.

8.2. Журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ХҮСЭГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨСЛИЙГ ХЯНАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

№	Үндсэн агуулга	Шалгуур үзүүлэлт
1.1	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталж буй тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй байдал	Эрүүл мэндийн тухай хуулийн 19.4 дэх хэсэгт заасан “Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл”-тэй нийцэж буй эсэхийг дүгнэн бичих
Хоёр. Хүн амын хэрэгцээ, шаардлага		
2.1	Тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгууллага байгуулах үндэслэл, давуу тал, үр ашгийн тооцоо	Тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллага нь: <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаж байгаа эсэх; - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх болсон шалтгаан, өнөөгийн байдал, эрэлт, хэрэгцээ зэргийг сүүлийн 3 жилийн тоон мэдээлэл, тайланд үндэслэн бичих; - Мэргэжлийн түвшинд үзүүлэх чадамжтай эсэхийг тодорхойлон бичих.
2.2	Төслийг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ижил төрлийн эрүүл мэндийн байгууллагатай харьцуулсан харьцуулалт, тусгай зөвшөөрөл хүсэгчийн давуу байдал	Тухайн орон нутаг, дүүрэг, хороонд: <ul style="list-style-type: none"> - Ижил төрлийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагын тоо - Тэдгээр байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, тоног төхөөрөмж, тусламж үйлчилгээ, технологи, арга аргачлал, үнэ, удирдлага, зохион байгуулалт, цахимжуулалт, байр, орчин нөхцөлийн харьцуулалт, давуу, сул талыг тодорхойлон бичих. (Өрсөлдөгчийн судалгаа)
2.3	Тусламж үйлчилгээний үйлчлэх хүрээний хүн амын тоонд харьцуулан тооцсон байдал	Статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь хүн амын тоог дүүрэг, хороогоор (шаардлагатай тохиолдолд нас, хүйс, ажил эрхлэлт, нийгмийн байдал г.м) тооцон оруулах
2.4	Ядуу, эмзэг бүлгийн хүн амд хүрч үйлчлэх байдал	Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд харьяалах дүүрэг, хорооны ядуу эмзэг, бүлгийн хүн амын тоог тусгах, нийгмийн хариуцлагын хүрээнд эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан тусгах;
2.5	Эрүүл мэндийн салбарын өрсөлдөөнд нөлөөлөх байдал	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын алсын хараа, ойрын болон хэтийн зорилгыг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх; - Тухайн байгууллага нь өөрийн маркетингийн давуу талыг ашиглан тухайн чиглэлийн эрүүл мэндийн бусад байгууллагуудаас хэрхэн ялгарах, давуу тал, өрсөлдөөний үр дүнд ямар

		үр ашигтай ажиллах, эрүүл мэндийн салбарт ямар шинэчлэлт хийхээр төлөвлөсөн зэргийг тодорхой бичих.
Гурав. Санхүү, эдийн засгийн үндэслэл		
3.1	Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн дүн, санхүүжилт хийгдэх хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр	Төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр, орлого, зарлага, ашгийн тооцооллыг 3 жилээр тооцон боловсруулсан байх;
3.2	Төслийн орлого, өртгийн төсөөлөл, түүнтэй уялдуулсан үйлчлүүлэгчээс авах үйлчилгээний төлбөрийн төсөөлөл	Үйлчлүүлэгчээс авах төлбөрийн хэмжээнд нөлөөлж болох эрсдэлт хүчин зүйлийг тогтоож, түүнийг бууруулах чиглэлээр хийх зохицуулалт, арга хэмжээг төлөвлөж бичих (Тухайлбал өөрийн байр, олон жилийн худалдан авах гэрээ, үнийн тогтвортой байдлыг хангасан зэрэг нь төлбөрийн хэмжээг нэмэхгүй байх боломжийг бий болгоно гэх мэтээр өөрийн онцлог байдлыг тусган дүгнэж бичих)
3.3	Төсөл хэрэгжүүлснээр байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэх, бүрэн хүчин чадлаараа тогтвортой ажиллах нөхцөлд үйлчлүүлэх хүн амын тооны төсөөлөл, нэг эрүүл мэндийн ажилтанд ногдох үйлчлүүлэгчийн тоо, үйлчилгээний зардал, төлбөрийн хэмжээ, бүтээгдэхүүний борлуулалтын үнэ, төсвийг гурван жилээр тооцсон санхүүгийн тооцоолол	Байгууллагын үйл ажиллагааг эхлүүлэх, цаашид бүрэн хүчин чадлаараа тогтвортой ажиллах хүртэлх үйлчлүүлэгчдийн тоон төлөв байдал, нэг эрүүл мэндийн ажилтанд ногдох үйлчлүүлэгч, үйлчилгээний зардал, урсгал болон тогтмол зардал, төлбөрийн хэмжээ, бүтээгдэхүүний борлуулалтын үнэ зэргийг гурван жилээр тооцсон санхүүгийн тооцооны танилцуулга бичих;
Дөрөв. Тусламж, үйлчилгээний стандартыг хангасан байдлын дүн шинжилгээ		
4.1	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 13.6-13.20, Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1, 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын болон Олон улсын стандарт, удирдамж, дүрэм, журамд нийцүүлэн тодорхойлсон өөрийн байгууллагын үйл ажиллагааны төрөл, мэдээлэл	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд мөрдөх стандарт, удирдамж, эмнэл зүйн заавар, журам, хяналтын хуудсын талаар бичих, өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулах;
4.2	Тусламж үйлчилгээнд ашиглагдах техник тоног, төхөөрөмжийн жагсаалт, түүний техникийн үзүүлэлт, хүчин чадал, Монгол Улсын болон Олон улсын стандартад нийцсэн байдал	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагдах техник тоног төхөөрөмжийн хангамж, чанарын баталгаажилт нь тухай эрхлэх үйл ажиллагааны стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврыг хэрэгжүүлэхэд шаардлага хангаж байгаа эсэх талаар тусгах; - Эмнэлгийн тоног, төхөөрөмжийн зургийг хавсаргах ба жагсаалтыг Эрүүл мэндийн

		сайдын 2023 оны 100 дугаар тушаалын дагуу гаргах.
4.3	Тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах байгууллагын удирдлага болон хүний нөөцийн мэргэшсэн байдал	- Эрүүл мэндийн байгууллагыг үүсгэн байгуулагчийн танилцуулгыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 100 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, эрүүл мэндийн ажилтны мэдээллийг 2, 3 дугаар хавсралтын дагуу тус тус гаргаж, иргэний үнэмлэх, мэргэжлийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, хөдөлмөрийн гэрээний хуулбарыг хавсаргах.
4.4	Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа болон тусгай хог хаягдал, ариутгал, халдваргүйжүүлэлт, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө	- Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны талаар тухайн үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичигт хэрхэн туссан талаар дүн шинжилгээ хийж бичих; - Тусгай хог хаягдал, ариутгал, халдваргүйжүүлэлт, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийхтэй холбоотой төлөвлөгөөг гаргаж, хамтран ажиллах байгууллагын талаар дурдаж оруулах.
4.5	Барилга байгууламжийн зураг төсөл	Тухайн эрхлэх үйл ажиллагааны төрөлд холбогдох стандартын шаардлага хангасан барилга байгууламжийн гадаад бодит зураг болон дотоод схем, план зургийг талбайн хэмжээний хамт гаргах, Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг хавсаргах.

Тайлбар:


- Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр хүсэгчийн “Мэргэжлийн үйл ажиллагааны төсөл”-тэй танилцсан шинжээч үндсэн агуулгын дагуу тухайн төслийн товч, гол мэдээллийг томъёолон бичнэ.
- Төслийг хангалтгүй гэж үзсэн, агуулгыг бүрэн илэрхийлээгүй тохиолдолд “санал, зөвлөмж” хэсэгт маш тодорхой тусгаж бичнэ.

Мэргэжлийн үйл ажиллагааны төслийг дараах байдлаар дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Оноо (хувь)
1	Эрүүл мэндийн сайдын 2023 оны 100 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн үйл ажиллагааны төсөл”-ийн үндсэн 14 агуулгыг шалгуур үзүүлэлтийн үзүүлэлтийн дагуу бүрэн илэрхийлсэн бол агуулга бүрт 5 оноо - Агуулгыг бүрэн тусгасан бол – 5 оноо - Агуулгат тохироогүй, дутуу бол – 3 оноо - Огт тусгаагүй бол – 0 оноо	70 оноо (100%)

Үнэлэх нь:

Оноо (хувь)	Үнэлгээ
63 оноо (90%)	Хангалттай
63 онооноос доош (89%-аас доош бол)	Хангалтгүй



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧИЙН АЖЛЫН БАЙРНЫ
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ**

1. Аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн байгуулсан шийдвэр, бүдүүвч

- Хуулийн этгээдийн нэр
- Регистрийн дугаар
- Улсын бүртгэлийн дугаар
- Байгуулагдсан он
- Үйл ажиллагааны чиглэл
- Аж ахуйн нэгж, байгууллагын үүсгэн байгуулагч, эзэмшигчийн мэдээлэл
- Байгууллагын бүтцийн зураглал

2. Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

- Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэл
- Шинэ, сунгалт, нэмэлт өөрчлөлт (зурах)

3. Барилга байгууламжийн талаарх мэдээлэл

- Үйл ажиллагаа явуулж байгаа хаяг
- Барилгын нийт хэмжээ, зориулалт, талбайн хэмжээ
- Эзэмших, ашиглах эрхийн хэлбэр

Өөрийн өмчлөл
Түрээс

4. Хүний нөөцийн мэдээлэл:

- Нийт ажилтны тоо
- Гол мэргэжлийн мэргэжилтний мэдээлэл (хүснэгтээр, диплом, лицензийн хуулбар)

№	Овог, нэр	Мэргэжил, мэргэшлийн зэрэг	Гүйцэтгэх үүрэг, албан тушаал	Үндсэн/гэрээт	Ажилласан жил
1.					
2.					

5. Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэлийн талаарх гол мэдээлэл:

- Монгол Улсын стандарт
- Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журам, заавар
- Онцлог үйл ажиллагаа
- Онцлог бүтээгдэхүүний хадгалах нөхцөл, боломж
- Бусад

6. Ажлын байрны үнэлгээний дүн:

- Авах ёстой оноо, авсан оноо, дүгнэлт:

7. Үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж:

8. Шинжээчдийн багийн бүрэлдэхүүн, гарын үсэг:

9. Хугацаа (он/сар/өдөр):